



Иосеф Ах Нараа Уучилсан нь

ИВЭЭЛ Их Эзэн биднийг мэддэг бөгөөд бидэнд санаа тавьдаг.

Унших Зүйл

Эхлэл 42:1-9; 45:1-15; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 224-240.

Цээжлэх Ишлэл

"Та нарыг Их Эзэн уучилсны адил та нар бас уучил" (Колоссай 3:13).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Их Эзэн бидэнд хайртай учраас биднийг буруу зүйл хийхэд уучилдаг гэдгийг мэдэж авах болно.

Уучлагдсан гэдгээ мэдэрнэ.

Өөрсдөд нь найрсаг бус хандсан хүмүүсийг уучлах зүрх сэтгэл хайрлахын төлөө Их Эзэнээс гуйх болно.

Гол Санаа



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Иосеф улсдаа хааны дараа орох хамгийн чухал удирдагч байлаа. Өлсгөлөн болоход түүний ах нар Египетэд хоол худалдаж авахаар ирдэг. Тэд Иосефоос хоол хүнс асуух хэрэгтэй болж Иосеф тэднийг таньсан боловч ах нар нь түүнийг таньсангүй. Хэсэг хугацааны дараа Иосеф өөрийгөө хэн болохоо хэлэхэд тэд ихэд айв. Гэвч Иосеф олон жилийн өмнө өөрийг нь хороохыг завдсан ах нараа уучилж аймшигтай өлсгөлөнгийн үеэр

тэдний амьдралыг хамгаалуулсан Их Эзэний төлөвлөгөөний тухай ярьж өгчээ.

Энэ бол ивээлийн тухай хичээл

Уучлалт бол Бурханаас өгөгдсөн хамгийн өгөөмөр бэлэг юм. Тэр үнэхээр тэвчээртэй бөгөөд буруу зүйл хийх үед минь үргэлж уучилж байдаг. Иосеф ах нараа уучилсан шиг Бурхан үргэлж биднийг уучлахад бэлэн байдаг. Тиймээс бид ч мөн бие биенээ уучлах хэрэгтэй.

АРВАН ГУРАВ

Хичээлийн Төлөвлөгөө			
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух	
1 Бэлтгэх Ажил	10 минут	<i>А. Алдаагаа Засах</i> <i>Б. Есүс Биднийг Гэрэлтүүлдэг</i>	нэг удаагийн аяга эсвэл таваг, хайч, цаасан цүнх, наалддаг цаас цаасан эсвэл пластик уут, чулуу, Есүсийн зураг
* Залбирал ба Магтаал*	10 минут	133-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2 Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	цаасан эсвэл даавуун цүнх, хувцас, хүнсний хайрцаг
		Библи Судлал	Библи
		Цээжлэх Ишлэл	Библи
3 Хичээлээ Заах	15 минут	<i>Уучлалт бол Бэлэг</i>	янз бүрийн зураг, бэлэгний хайрцаг, <i>Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана</i> дууны ном
4 Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Чамд Өгөх Бурханы Бэлэг</i>	бэлэгний хайрцагны загвар (х. 149), цаас, өнгийн харандаа, ягаан целлофан, боодог цаас, резин, хайч, цавуу эсвэл наалддаг цаас

Багшийн Баяжуулалт

"Иосефын амьдрал нь Есүсийн амьдралыг санагдуулж байна." (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 239).

"Зовлон зүдгүүр дундах тэвчээр, ах нарыгаа уучлан өршөөх Иосефын сэтгэл нь агуу баатрын хүч чадлыг санагдуулам". (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 240).

Есүс болон Иосеф шиг та нар үргэлж уучилж байдаг уу? Таны амьдрал Есүсийн амьдралыг илтгэдэг үү?

Өрөөний Зохион Байгуулалт

Нэгдүгээр хичээлийн тайзны заслыг хэрэглэ. "Хааны өрөө" гэсэн чимэглэлийг ашиглаарай.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.



Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Алдаагаа Засах

Хэрэгтэй зүйлс:

- жижиг нэг удаагийн аяга эсвэл таваг
- хайч
- цаасан цүнх
- наалддаг тууз

Юуны өмнө, нэг удаагийн аягыг 3 эсвэл 4 хэсэгт зүсэж цүнхэн дотор хийнэ. 2 хүүхэд бүрт нэг цүнх бэлд. Хүүхдүүдийн хосыг өөрсдөөр нь сонгуулж хос болгонд цүнх өгнө. Аяга болон тавагнуудыг буцааж наахад зориулан цавуу өгөөрэй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах цаг гаргаарай. Асуух: **Аяга эсвэл тавгийг буцааж наахад хэцүү байна уу? Эвдрэхээсээ өмнө ямар байсан шигээ харагдаж чадаж байна уу? Хэн нэгэн буруу зүйл хийснийхээ дараа их хэцүү байдаг. Засаж залруулах нь яг "Уучлаарай" гэж хэлж буйтай адил. Муудалцсан нөхөрлөлийг дахин сэргээх том арга шүү.**

Иосефын ах нарыг санаж байна уу? Олон жилийн өмнө тэд Иосефыг боол болгон зарсан юм. Өнөөдрийн түүхэнд Иосефын ах нар хоол хүнс авахаар Египетэд ирдэг. Иосеф тэдэнд хэрхэн хандсаныг бид удахгүй мэдэх болно. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

(From Linda Prenzlou and Ilene Allinger Candreva, *More Faith-Building With Preschoolers* [St. Louis, Mo: Concordia Publishing House, 1999], p. 59.)

Хэрэгтэй зүйлс:

- цаасан эсвэл гялгар уут
- чулуу
- Есүсийн зураг

Б. Есүс Биднийг Гэрэлтүүлдэг

Чулуу эсвэл хүнд эд зүйлсээр 3 тусдаа газар хийх том хүн хэрэгтэй. Есүсийн зургийг 4 дэх газар дээр тавиад хүүхэд бүрт уут өг. Хэлэх: **Та нарыг ууртай болгож болох зарим зүйлийг би та нарт хэлнэ. Манай туслагч бүр дээр очиход чинь тэд чиний уутанд чулуу хийх болно.**

Хэн нэгэн чиний хайртай тоглоомыг нууж байна.

Танай дүү саяхан барьж дууссан байшинг чинь нураачихлаа.

Дүүгийн чинь хийсэн зүйлийн төлөө ээж чинь чамайг загнана.

Ахиад хашаандаа тоглохыг найз чинь зөвшөөрөхгүй байх.

Зурсан зураг дээр чинь хэн нэгэн сүү асгах.

Хэлэх: Хэрвээ бид хүмүүсийг уучилж байхгүй бол энэ нь маш хүнд ачаа үүрч явж байгаатай адил. Бидний муу мэдрэмж биднийг улам доройтуулж улам л ууртай болгодог. Үүнээс гарах нэг арга бол Есүст бүхнээ хэлж түүнээс тусламж гуйх явдал юм. Хэрвээ бид хэн нэгнийг уучлах эсвэл хэн нэгнээс уучлалт гуйвал энэ нь яг л ачаагаа авч хаясантай адил. Одоо нааш ирээд хүнд чулуугаа Есүст өгөөрэй. Тэгээд Есүст өөрийн муу мэдрэмжээ өгвөл Тэр чамайг буцаад баяртай болоход туслах болно.


Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Чи буруу зүйл хийснийхээ дараа ямар байдаг вэ? Дотроо их хэцүү байдаг уу? Уучлалт гуйсныхаа дараа чамд ямар байдаг вэ? Дээр болдоггүй гэж үү? Есүс хэзээ биднийг уучилдаг вэ?** (Хэрвээ бид Түүнээс уучлалт гуйж гэмшвэл.) **Есүс бидэнд хайртай учраас биднийг уучилж байдаг. Тийм ч учраас бид бие биенийгээ уучилж чадах ба энэ маш сайн хэрэг юм. Өнөөдрийн хичээлийн гол утга санаагаа хамтдаа хэлцгээе:**



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нохорлол

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох дуунууд

"Уучлалт бол бэлэг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 75*)

"Би уучлагдсан" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 76*)

"Есүс инээмсэглэдэг бас уучилдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 77*)

"Их Эзэн хамгийн сайн нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 88*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэлээс түүх уншиж өгөөрэй.

Хандив

Хэлэх: **Өргөлөө өгөөд Их Эзэнд баярлалаа гэж хэлцгээе.**

Залбирал

Есүс биднийг уучилдаг шиг бид ч мөн бусдыг уучилдаг байхын төлөө Бурханаас гуйгаарай.

* Залбирал ба Магтаалын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- чемодан
- хувцас
- хүүхэд бүрт жижиг цаасан уут
- будаа, эрдэнэ шиш эсвэл өөр ямар нэгэн буудай

Түүхийг уншиж эсвэл ярьж өгөх

Арван залуу эр холын аянд явахаар бэлдэж байв. Тэд бүгд ах дүүс. Үнэндээ тэдэнд нэг дүү бий. Гэвч тэр нь хамт явахгүй. 10 залуу эрийг төсөөлөөд үз л дээ: Нэг, хоёр, гурав..... [Хүүхдүүд танитай хамт 10 хүртэл тоолно. 2 гаран дээрээ хуруугаа үзүүлэх.] Тэд Египет рүү хол аянд явах хэрэгтэй болжээ.

Аян замд явах болохдоо чи юу хийдэг вэ? [Хувцсаа янзлах гэх мэт.] Энэ цүнхийг бэлдэж бооход та нар надад туслаач. [Хувцастай чемоданыг бэлдэхэд хүүхдүүд

танд тусална. Ярьж байхдаа хүүхэд бүрт нэг нэг жижиг цаасан уут өг.]

Бүх зүйл бэлэн болсны дараа тэд эхнэрүүдээ үнсэж, хүүхдүүдээ тэврээд аавтайгаа салах ёс хийв. [Хүүхдүүд танитай хамт явж байхдаа гараа даллах.] Тэд илжигээ унаад Египет рүү явлаа. Тэд амралтанд яваагүй ээ. Тэдэнд хоол хүнс хэрэгтэй болсон учир Египет рүү яаран явж байв. Тэдний амьдарч байсан газарт бараг хоол хүнсгүй болжээ. Удаан хугацаагаар бороо ороогүй учир ургамал ногоо ч ургасангүй. Тэд гэр бүлээ тэжээхийн тулд маш их хэмжээний хоол хүнс цуглуулах хэрэгтэй байлаа.

Арван залуу эр их удаан явсаар байлаа. Яг энэ ах дүүсийн явсан шиг бүгдээрээ мөн чемоданаа аваад явъя [Өрөөгөөр тойрон яваад, явж байхдаа хүүхдүүдээс асуух нь: Хэнд их олон ах нар байсныг та нар санаж байна уу? [Иосеф], Мөн Иосеф хаана байсан бэ? [Египетэд]

Эцэст нь ах дүүс Египетэд ирлээ. "Энэ байшинг хараач. Тэнд дүүрэн будаа тариа байна. Гайхалтай". [Будаа тариаг заах]. Тэд хоол хүнс авахыг хүссэн учраас будаа тарианы асуудлыг хариуцаж байсан засгийн газрын албан

газар луу яаран явна. Хариуцаж байсан хүн нь Иосеф байжээ. Ах нар нь Иосефыг их олон жилийн турш хараагүй. Тэр их том болсон байлаа. Одоо тэр яг л Египет хүн шиг хувцаслачихсан. Мөн Египет нэртэй болсон. Тиймээс ах нар нь түүнийг таньсангүй. Гэвч Иосеф таньж байлаа.

Ах нар нь Иосефын өмнө бөхийхөд тэр зүүдээ санажээ. Түүний бага байхдаа зүүдэлсэн зүүдийг нь та нар санаж байна уу? Олон жилийн өмнө тэр арван нэгэн багц буудай нэг багц буудайны өмнө бөхийж байна гэж. Мөн тэр нар сар 11 од түүний өмнө бөхийж байна гэж зүүдэлсэн юм. Ах нар нь түүний зүүдэнд дургүй байсныг санаж байна уу? Гэвч түүний зүүд биелэжээ. Яаж бөхийхийг та нар мэдэх үү? [Хүүхдүүдэд бөхийж үзүүлэх]. Тэд хүндлэл үзүүлж бөхийсөн бөгөөд Иосефын урд бөхийж байна гэдгээ огтхон ч мэдсэнгүй.

Иосефын ах нар хэрэгтэй хоол хүнсээ авлаа. Одоо тэдний цүнх хоол хүнсээр дүүрэн байна. [Хэсэг будааг хүүхэд бүрийн уутанд хийж өгөх]. Тэд Иосефыг танихгүй байсаар Канаанд буцаж ирэв.

Хэсэг хугацааны дараа, тэд авсан бүх хоол хүнсээ дуусах цагт ахин Египет рүү явж хүнс авах хэрэгтэй болж энэ удаа арван нэгэн ах дүүс бүгд явав. Тэд ахиад л Иосефыг харсан боловч таньсангүй. Арван нэгэн ах нэг дүү нь түүний өмнө бөхийлөө [Бөхийж үзүүлэх]. Иосеф тэднээс их олон асуулт асуулаа. Тэр тэднийг гэртээ аваачихад арван нэгэн ах дүүс нь бага зэрэг санаа зовж байв. Египетийн албан хаагч тэдэнд их сайхан хандахын юу нь чухал вэ? Иосеф: "Зарц нараа, гадаа гар. Би энэ хүмүүстээ ганцаар ярилцмаар байна" гэв.

Иосеф ах нартаа үнэнээ хэлэх цаг нь болсон гэж бодоод зарц нарыг гарсны дараа "Би бол Иосеф. Та нарын дүү. Манай аав амьд уу?" гэж асуулаа.

Ах нар нь итгэж ядна. Иосеф? Одоо тэд бүр ч их санаа зовж айж хойшоо ухран байв. *[Хүүхдүүд хойшоо нэг алхана]*. Яагаад гэдгийг нь мэдэх үү? Тийм ээ, тэд Иосефт их өсөрхөж байсан ба түүнийг боол болгон худалдсан юм. Одоо тэд Иосеф өшөөгөө авах гэж байна гэж бодож байгаа.

Гэвч Иосеф: "Наашаа ойртоод ир. *[Хүүхдүүд тань руу ойртон ирэх]*". Тэгээд ихэд элгэмсэгээр: "Би та нарын Египетэд боол болгон зарсан дүү чинь билээ. Гэхдээ санаа бүү зов. Их Эзэн намайг тийш нь илгээсэн юм. Тэр намайг энд хүмүүсийн амийг авруулахаар илгээсэн. Одоо ахиад олон жил өлсгөлөн болох учраас Бурхан намайг та нарын амийг авруулахаар энд илгээсэн юм" гэжээ.

Ах нар нь ихэд гайхсан ба Иосеф хамгийн бага дүү нь болох Бенжаминаас эхлээд ах нараа бүгдийг нь тэврэв. *[Бүх хүүхдүүдийг тэвэр]*. Иосеф баярласандаа уйлчихлаа. Арван ах нь хийсэн зүйлдээ гэмшин түүнээс уучлалт гуйж Иосеф өөрсдийг нь уучилсанд ихэд баяртай байв.

Иосеф тэдэнд аав болон гэр бүлүүдээ авчран Египетэд амьдарвал өлсөхгүй гэж хэлээд тэдэнд хэсэг газар хуваан өгье хэмээн амлалаа. Аавдаа өөрийгөө амьд байгаа гэдгийг хэлээрэй хэмээн гуйгаад тэдэнд гэртээ авч явах бэлэг өгжээ. *[Хүүхдүүдэд хувцас өгч, уутанд нь будаа нэмж өг.]* Ах нарынх нь хувьд бэлэг авснаас илүү Иосеф тэднийг уучилсан нь их том баяр байлаа.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Иосефын ах нар түүний зүүдийг санасан бол уу?** Та нар зүүдийг нь санаж байна уу? Зүүд нь юу байсан бэ? Ах нараа уучилсан гэдгээ Иосеф хэрхэн харуулсан бэ? Ах нарыгаа муу зүйл хийсэн ч Иосеф яагаад уучилсан бэ? Иосеф ах нарыгаа уучилсаны дараа ямар байсан бол? Ах нарт нь ч мөн ямар байсан бэ? Та нар уучлагдах эсвэл уучилсаныхаа дараа ямар байдаг вэ?

Иосеф Бурханд хайртай мөн Түүн шиг байхыг хүсдэг байсан учир ах нараа уучилж чаджээ. Биднийг ч мөн буруу зүйл хийхэд Их Эзэн үргэлж уучилж байдаг. Та нар Их Эзэн болон Иосеф шиг байхыг хүсэж байна уу? Гол санаагаа санаж байна уу? Хамтдаа хэлцгээе:



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Библиэ нээгээд Эхлэл 42:1-9-г гаргана уу. Бүлгийг заагаад ингэж хэл: **Бидний өнөөдрийн үзсэн зүйл Бурханы үг болсон Библийн энэ хэсэгт бичигдсэн байна** гээд чанга уншиж өгөөрэй.

Хэрэгтэй зүйлс:

Библи

Бататгах нь

Хэлэх: **Иосефын аав ах нарыг нь яагаад Египет рүү явуулдаг вэ? Эхний аялалаар хэдэн хүн явсан бэ? Тэд яагаад хоёр дахь удаагаа Египетэд ирсэн бэ? Иосеф өөрийгөө илчлэхэд тэд юу гэж бодсон бэ? Тэд юунаас айв? Иосеф тэдэнд юу гэж хэлсэн бэ? Тэд хаана амьдрахаар явсан бэ?**

Иосеф ах нараа уучилсан уу? Бусдыг уучлах талаар чи юу гэж бодож байна вэ? Иосеф ах нараа уучлахдаа хэнтэй адилхан байсан бэ? Чамд сайн бус хандсан хүмүүсийг чи уучлахад чи хэнтэй адилхан байдаг вэ? Санацгаая:



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

Намайг дагаад хэлээрэй.

Цээжлэх Ишлэл

Хэрэгтэй зүйлс:

□ Библи

Библиэ нээгээд Колоссай 3:13-г гарган **"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна"** гээд ишлэлийг чангаар

унш. **"Та нарыг Их Эзэн уучилсаны адил та нар бас уучил"** гэсэн ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.



Та нарыг

Бусдыг заах.



Их Эзэн

Дээшээ заах.



уучилсны адил

Зүүн гарын хуруунуудаа баруун алган дээрээ тавин гадагш илэх.




та нар бас

Бусдыг заах.



уучил.

Уучил гэсэнтэй адил хөдөлгөөн.



Колоссай 3:13

Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

3

Хичээлээ Заах

Уучлалт бол Бэлэг

Хэрэгтэй зүйлс:

- янз бүрийн эд зүйлсийн зураг
- бэлэгний хайрцаг
- *Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана* дууны ном

Юуны өмнө, Хүмүүс уучлалт гуйж болох зүйлийг илэрхийлсэн эд зүйлс эсвэл зурагнуудыг хайрцагт хий. (Ямар нэгэн зүйлийг эвдэх, уураа барьж чадахгүй байх, хуваалцахгүй байх, зодолдох, эцэг эхийнхээ үгэнд орохгүй байх, хулгай хийх, найздаа муу хандах, атаархах гэх мэт).

Асуух: **Чи хэзээ уучлалт гуйх вэ?** (Буруу зүйл хийгээд гэмшвэл). **Уучлах гэдэг нь ямар утгатай вэ?** (Үүний тухай мартагч)

Уучлалт бол Их Эзэнээс өгөгдсөн бэлэг юм. Бид Есүсээс уучлалт гуйх үед Тэр бидэнд бэлэг өгдөг. Чи ч мөн хэн

нэгнийг уучилвал тэдэнд бэлэг өгсөнтэй адил.

Хүүхдүүд саналаараа гарч ирээд хайрцагнаас ямар нэгэн зураг аваад зурган дээр хэн нэгэн ямар буруу зүйл хийж байгаа болон юуны төлөө уучлалт гуйх хэрэгтэй тухай тайлбарлах хэрэгтэй.

Бататгах нь

Асуух: **Бурхан биднийг уучилсан**

гэдэгт баяртай байна биш гэж үү? **Бурхан бидэнд ийм сайн байгаад нь зориулж Түүнд юу хэлмээр байна?** (Баярлалаа, Их Эзэн хамгийн сайн нь, Би Их Эзэнд хайртай гэх мэт.) **Бид мөн өөр юу хийх хэрэгтэй вэ?** (Бусдыг уучлах.) **Бусдыг уучлах үргэлж амархан байдаг гэж үү? Хэрвээ тэд үнэхээр биднийг хороохоор завдсан бол яах уу?**

Иосефыг санаж байна уу? Ах нар нь их муу хүмүүс байсан ч Иосеф тэднийг уучилсан юм. Үүнийг хийхэд нь Их Эзэн түүнд тусалсан гэдэгт би итгэлтэй байна. Бусдыг тусалхад Бурхан чамд ч бас туслах болно. Уучлал нь Бурханаас бидэнд өгөгдсөн бэлэг болж байгаа тухай дуу дуулцгаая. "Уучлал бол бэлэг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана*, № 75) дууг дуул. Хэд хэдэн удаа давт. **Хичээлийн гол санаагаа хамтдаа хэлцгээе:**



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

4

Хичээлээ Хуваалцах нь

Чамд Өгөх Бурханы Бэлэг

Хэрэгтэй зүйлс:

- бэлэгний хайрцагны загвар (149-р хуудас)
- цаас
- өнгийн харандаа
- ягаан гялгар цаас
- бэлэг боодог цаас
- резин
- хайч
- цавуу эсвэл скоч

Юуны өмнө, бэлэгний хайрцагны загвар зургийг хүүхэд бүрт бэлд (149-р хуудас). Тэгээд доорх хоёр зүйлийн аль нэгийг хийгээрэй.

1. Юунд уучлал гуйх гэснээ болон уучлах зүйлээ бэлэгний хайрцаг дээр зөвхөн ягаан өнгийн харандаагаар хүүхдүүд зурна (Том хүний тусламж авч болно). Тэгээд хүүхэд бүрт дөрвөлжин ягаан өнгөтэй гялгар цаас өгөөд зурсан зураг Бурханаас уучлалт гуйх үед яг л энэ

гялгар цаас зургийг алга болгож байгаатай адил гэмийг нь арчиж хаях болно гэдгийг тайларлаж өг.

2. Хүүхдүүд бэлэгний хайрцагийг өнгө өнгийн харандаагаар будаж бас чимэглээд резинээр бооно.

Бататгах нь

Асуух: Хэн нэгэн чамайг уучлахад чамд ямар байдаг вэ? Чи өөрөө хэн нэгнийг уучлахад чамд ямар байдаг вэ? Бурхан биднийг уучилдаг мөн бидний хийсэн гэмийг мартдаг гэдгийг мэдээд та нар юу гэж бодож байна вэ? Их Эзэн биднийг уучлах нь бэлэг авч буйтай адил шүү.

Бэлэгнийхээ хайрцагийг гэртээ авч яваад өөрийнхөө муухай хандсан хүнтэй хуваалцаж тэднээс өөрийгөө уучлах эсэхийг асуугаарай.

Эсвэл чамаас уучлал гуйсан ч одоо хүртэл чиний уур хүрч байгаа хүнтэй ч хуваалцаж болно. Яагаад гэмшсэнээ хэлээд уучлалт гуйхаа мартуузай. Эсвэл тэр хүндээ өөрийг нь аль хэдийн уучлаад уураа гарсныг хэлээрэй. Тэдэнд бэлэгний хайрцагны зургаа өгөөд Иосеф хэрхэн ах нараа уучилсан тухай ярьж өг. Их Эзэн бидэнд хайртай учраас биднийг уучилж байдаг гэдгийг тэдэнд сануул.

Гол санаагаа хамтдаа хэлцгээе:



Бурхан биднийг өршөөдөг учраас бид ч мөн бусдыг уучилж чадна.

Хичээлийн Хаалт

Залбирлын үеэр хүүхдүүд гэмээ үнэхээр ойлгож Бурханаас уучлалт гуйхын төлөө залбираарай. Бусдыг үргэлж хайрлаж уучилж байхын төлөө залбирна уу.

Иосеф Ах Нараа Уучилсан нь

Унших Зүйл

Эхлэл 42:1-9;
45:1-15; Эцэг
Өвгөд ба
Зөнчид, х. 224-
240.

Цээжлэх Ишлэл

"Та нарыг Их
Эзэн уучилсны
адил та нар бас
уучил" (Колоссай
3:13).

Гол Санаа

**Бурхан биднийг
өршөөдөг
учраас бид ч
мөн бусдыг
уучилж чадна.**

Хэн нэгэн танд үнэхээр муу зүйл хийж байсан уу? Та уучилсан уу? Уучилахад амархан байсан уу? Иосефын ах нар түүнд үнэхээр муу зүйл хийжээ.

Иосефын урд арван нэгэн залуу их л айсан мэт зогсож байлаа. Ордонд байгаа бусад хүмүүст эдгээр арван нэгэн залуу танихгүй гадны улс байв. Өлсгөлөнгийн үеэр Египетэд ирж хоол хүнс авахаар ирсэн хүмүүс байлаа.

Гэвч Иосеф тэднийг ах нараа болохыг, ахиад хэзээ ч уулзахгүй гэж бодсон ах нараа болохыг мэджээ.

Иосефын бодол өмнөх дурсамжаар дүүрлээ. Арван ах нь түүнд хэрхэн хандсаныг тэр санаж байв. Ах нар нь түүнийг харанхуй нүхэнд шидэж дараа нь Египет хүнд боол болгон зарсан тэр аймшигт өдрийг Иосеф саналаа.

Тэдгээр залуусын урд зогсож буй Египетийг тэр чигээр нь захирдаг хааны яг доод албан тушаалтан, Египетийн ханхүү мэт харагдаж буй тэр хүн бол тэдний төрсөн дүү гэдгийг хэлэх цаг нь болжээ.

"Явцгаа, гадаа хүлээж бай" гэж Иосеф зарц нартаа хэлэв.

Удалгүй Иосефтой хамт түүний ах нар болон дүү нь л өрөөнд үлдлээ. Иосефын хацрыг даган нулимс урсаж "Би бол Иосеф, та нарын дүү байна, аав маань амьд байна уу?" гэж хэллээ.

Ах нар нь гайхсаар ... Египетийн энэ чухал удирдагч үнэхээр бидний дүү гэж үү? Тэд гэнэт айж эхлэв. Иосеф тэдэнд юу хийх бол? Тэд түүнд ихэд муухай

хандсан шүү дээ. Тэд дүүгээ боол болгон худалдчихсан шүү дээ.

Иосеф ах нарыгаа их айсан байгааг мэдээд "Наашаа ойртоод ир. Би та нарын дүү Иосеф. Та нар намайг Египетэд боолоор зарсан. Гэхдээ бүү санаа зов. Бурхан намайг энэ газар руу илгээсэн билээ. Энэ өлсгөлөнгийн үеэр та нарын амийг авруулахаар Их Эзэн намайг энд дуудсан юм. Одоо хурдан гэртээ харь. Намайг Египетийг захирч гэдгийг аавд маань хэл. Тэгээд түүнийг энд авчир. Мөн гэр бүлүүдээ ч авчир. Миний хажууд амьдар. Энэ өлсгөлөнгийн үеэр би та нарыг асрах болно" хэмээн их л



ээлдэгээр хэллээ.

Тэгээд Иосеф болон түүний ах нар их л удаан ярилцлаа. Иосеф ах нараа уучилсанаа тэдэнд дахин дахин л хэлж байв. Иосеф гэрийнхээ талаар олон асуулт асууж байв.

Реубен уртаар санаа алдаад их л сайхан байлаа. Тэр уучлагдсан шүү дээ.

Реубен бусад ах дүү нараа хараад тэдний хүүхдүүдийнхээ тухай Иосефт хөгжилтэй яриа ярьж өгч байхыг анхааралтай сонсож байв. Реубен бусад дүү нараа ч гэсэн уучлагдсан гэдгийг мэджээ. Тэд Египетэд аав болон гэр бүлүүдээ авчран амьдрах болно. Эцэст нь Иосеф ч аавтайгаа дахин уулзах болно шүү дээ.

Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн туршид өдөр бүр Библийн түүхээ уншиж, цээжилсэн ишлэлийг нь хамтдаа давтаарай.

Та нарыгБусдыг заах.

Их ЭзэнДээшээ заах.

уучилсны адилЗүүн гарын хуруунуудаа баруун алган дээрээ тавин гадагш нь илэх.


та нар басБусдыг заах.

уучил.Зүүн гарын хуруунуудаа баруун алган дээрээ тавин гадагш нь илэх.

Колоссай 3:13Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

Хүүхдээрээ том чулуу олуулаад авчруулаарай. Хэлэх нь: Чи үүнийг өдрийн турш өргөөд явж чадах уу? Хэрвээ бид бусдыг уучилж чадахгүй байвал энэ нь том чулуу үүрч явахтай адил юм. Бидний муу мэдрэмж биднийг доройтуулж байдаг. Одоо чулуугаа тавь. Хэрвээ бид бусдыг уучилбал энэ нь хүнд ачааг авч хаясантай адил.



Даваа

Цаасыг таван хэсэг ураад буцааж нааж байхдаа асуух нь: Урагдахаасаа өмнө ямар байсан шигээ харагдаж байна уу? Хэрвээ хэн нэгэн буруу зүйл хийвэл тэд дотроо ихэд шаналдаг. Алдаагаа засах нь "Уучлаарай" гэж хэлсэнтэй адил.

Мягмар

Шаббат хичээл дээр хийсэн Их Эзэний бидэнд бэлэглэсэн уучлалтыг илэрхийлсэн бэлэгний хайрцгаа хэн нэгэнтэй хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай.

Уучлалт гуйж байсан үеийнхээ тухай хүүхдэдээ ярьж өгөөрэй.



Лхагва

Асуух нь: Чамайг бусдыг уучлахад Есүс инээмсэглэдэг гэж бодож байна уу?

Өнөөдөр хийсэн бүх л муу зүйлийнхээ төлөө уучлалт гуйхад нь хүүхдээ урамшуулж биднийг үргэлж уучилж байдаг Бурханд талархаарай.

Пүрэв

Иосефын ах нарын хийсэн муу зүйлийн тухай ярилцаж байхдаа сонингийн цаасан дээр хүүхдийнхээ бас өөрийнхөө гарыг үр. Бохир болсон гараа харцгаа. Тэгээд бие биенийхээ гарыг угаа. Гараа угаах нь Их Эзэн биднийг уучилж гэмээ угаахтай адил гэдгийг тайлбарлаж өгөөрэй.

Баасан

Библийн түүхийг гэр бүлтэйгээ хамт жүжиглээрэй. "Их Эзэн хамгийн сайн нь" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана*, № 88) дууг дуулаад хамгийн сүүлийн мөрийг нь "Тэр намайг уучилдаг" гэж солиорой.

Иосефын адил бусдыг уучилдаг байхад туслахын төлөө Есүсээс гуйн залбираарай.